

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД ТӨА-2024/251/ НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨР ШИРЭЭТ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер: О.Амаржаргал

Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК Гүйцэтгэх
захирал: С.Оюунгэрэл

Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/84

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэж байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 31,677.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019000094

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэг “Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулна” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88,6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>117,881,337.66</u>	<u>71,405,221.60</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	85,633,729.78	31,677,671.95
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	85,633,729.78	31,677,671.95
3121	Төгрөг	85,633,729.78	31,677,671.95
31211	Төрийн сангийн харилцах	85,633,729.78	31,677,671.95
33	АВЛАГА	35,888.23	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	35,888.23	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,211,719.65	39,727,549.65
351	Түүхий эд материал	17,345,215.23	20,815,515.23
35110	Тусгай зориулалттай материал	17,345,215.23	20,315,215.23
35130	Эм боох материал	00.00	500,300.00
354	Хангамжийн материал	14,866,504.42	18,912,034.42
35410	Бичиг хэргийн материал	802,200.00	1,334,200.00
35420	Аж ахуйн материал	12,716,304.42	15,098,404.42
35450	Барилгын засварын материал	1,348,000.00	228,000.00
35460	Хүнсний материал	00.00	2,251,430.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>267,646,049.88</u>	<u>256,514,478.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	267,646,049.88	256,514,478.00
392	Биет хөрөнгө	262,274,049.88	251,142,478.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	258,632,205.00	258,632,205.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-25,799,998.08	-33,499,863.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,656,450.00	22,656,450.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,928,526.36	-9,027,271.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,938,816.00	15,938,816.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,106,946.68	-4,439,908.30
39217	Ном	882,050.00	882,050.00
393	Биет бус хөрөнгө	5,372,000.00	5,372,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,372,000.00	5,372,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>385,527,387.54</u>	<u>327,919,699.60</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>36,388.23</u>	<u>891.20</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,388.23	891.20
413	Өглөг	36,388.23	891.20
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	891.20
4136	Бусад өглөг	36,388.23	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	36,388.23	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>385,490,999.31</u>	<u>327,918,808.40</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	385,490,999.31	327,918,808.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	125,616,943.64	125,616,943.64

51101	Өмч: - төрийн	125,616,943.64	125,616,943.64
512	Хуримтлагдсан үр дүн	83,693,040.63	26,120,849.72
51210	Өмнөх үеийн үр дүн	83,693,040.63	83,693,040.63
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-57,572,190.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	176,181,015.04	176,181,015.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	385,527,387.54	327,919,699.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	646,559,810.41	232,189,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	304,509,010.41	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	304,509,010.41	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	304,509,010.41	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	304,509,010.41	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,331,500.00	232,189,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	209,910,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	209,910,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	303,719,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,971,900.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,971,900.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,359,600.00	22,279,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,359,600.00	22,279,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	257,818,893.10	289,761,190.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	257,818,893.10	289,761,190.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	237,336,341.36	286,720,982.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,169,069.31	182,791,916.97
210101	Үндсэн цалин	121,085,120.45	132,297,300.06
210102	Нэмэгдэл	17,971,853.75	43,239,592.61
210104	Урамшуулал	6,112,095.11	7,255,024.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,890,234.17	23,018,832.06
210201	Тэтгэврийн даатгал	12,899,990.61	15,680,612.38
210202	Тэтгэмжийн даатгал	1,527,700.41	1,844,778.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,191,920.24	1,467,022.48
210204	Ажилгүйдлийн даатгал	290,822.25	358,861.96
210205	Эрүүл мэндийн даатгал	2,979,800.66	3,667,557.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,949,370.00	18,738,791.82
210301	Гэрэл, цахилгаан	1,597,994.00	2,576,306.92
210302	Түлш, халаалт	12,351,376.00	16,162,484.90

2104	Хангамж, бараа материалын зардал	92,000.00	00.00
210401	Бичиг хэрэг	92,000.00	00.00
2105	Нормативт зардал	36,070,100.00	39,266,470.00
210502	Хоол, хүнс	33,714,700.00	39,266,470.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,355,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	4,500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	820,000.00	593,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	820,000.00	593,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,845,567.88	21,811,071.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,104,336.00	9,158,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,398,750.00	1,520,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,342,481.88	11,131,571.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,482,551.74	3,040,208.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,568,400.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,868,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,700,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,914,151.74	3,040,208.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,914,151.74	3,040,208.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	388,740,917.31	-57,572,190.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	388,740,917.31	-57,572,190.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	342,050,800.00	232,189,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	342,050,800.00	232,189,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	209,910,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	209,910,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	303,719,300.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,971,900.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,971,900.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,359,600.00	22,279,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,359,600.00	22,279,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	253,764,170.22	286,145,057.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	253,764,170.22	286,145,057.83

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	233,281,618.48	283,104,849.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,169,069.31	182,791,026.77
210101	Үндсэн цалин	110,152,769.97	130,592,510.42
210102	Нэмэгдэл	26,382,762.24	44,943,492.05
210104	Урамшуулал	8,633,537.10	7,255,024.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,890,234.17	23,018,831.06
210201	Тэтгэврийн даатгал	12,924,190.42	15,499,485.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,527,700.82	1,917,020.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,188,560.55	1,389,002.11
210204	Ажилгүйдлийн даатгал	289,981.95	378,782.87
210205	Эрүүл мэндийн даатгал	2,959,800.43	3,834,540.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,949,370.00	18,738,791.82
210301	Гэрэл, цахилгаан	1,597,994.00	2,576,306.92
210302	Түлш, халаалт	12,351,376.00	16,162,484.90
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	00.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	00.00
2105	Нормативт зардал	35,092,659.00	41,517,900.00
210502	Хоол, хүнс	35,092,659.00	41,517,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	820,000.00	598,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	820,000.00	598,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,756,786.00	15,940,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,257,536.00	14,142,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,499,250.00	1,797,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,482,551.74	3,040,208.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,568,400.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,868,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,700,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,914,151.74	3,040,208.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,914,151.74	3,040,208.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	88,286,629.78	-53,956,057.83
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,652,900.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,652,900.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,652,900.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,652,900.00	00.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2,652,900.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	85,633,729.78	-53,956,057.83
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	85,633,729.78
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	85,633,729.78	31,677,671.95

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,616,943.64	176,181,015.04	83,693,040.63	385,490,999.31
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	125,616,943.64	176,181,015.04	83,693,040.63	385,490,999.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	125,616,943.64	176,181,015.04	83,693,040.63	385,490,999.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-57,572,190.91	-57,572,190.91
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,616,943.64	176,181,015.04	26,120,849.72	327,918,808.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	295,543,600.00	263,866,057.83	31,677,542.17	89.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	295,543,600.00	263,866,057.83	31,677,542.17	89.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,543,600.00	263,866,057.83	31,677,542.17	89.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,909,100.00	182,791,026.77	27,118,073.23	87.08
210101	Үндсэн цалин	145,336,700.00	130,592,510.42	14,744,189.58	89.86
210102	Нэмэгдэл	59,553,800.00	44,943,492.05	14,610,307.95	75.47
210104	Урамшуулал	5,018,600.00	7,255,024.30	-2,236,424.30	144.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,238,800.00	23,018,831.06	3,219,968.94	87.73
210201	Тэтгэврийн даатгал	17,842,300.00	15,499,485.71	2,342,814.29	86.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,099,000.00	1,917,020.15	181,979.85	91.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,679,300.00	1,389,002.11	290,297.89	82.71
210204	Ажилгүйдлийн даатгал	419,900.00	378,782.87	41,117.13	90.21
210205	Эрүүл мэндийн даатгал	4,198,300.00	3,834,540.22	363,759.78	91.34
2105	Нормативт зардал	42,854,400.00	41,517,900.00	1,336,500.00	96.88
210502	Хоол, хүнс	42,854,400.00	41,517,900.00	1,336,500.00	96.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	599,300.00	598,300.00	1,000.00	99.83
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	599,300.00	598,300.00	1,000.00	99.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,942,000.00	15,940,000.00	2,000.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,144,200.00	14,142,200.00	2,000.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,797,800.00	1,797,800.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	233,537,100.00	209,910,000.00	23,627,100.00	89.88
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	233,537,100.00	209,910,000.00	23,627,100.00	89.88
131001	Улсын төсвөөс санхүүжих	233,537,100.00	209,910,000.00	23,627,100.00	89.88
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	85,633,729.78	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	31,677,671.95	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэг нь 2023-2024 оны хичээлийн жилд “Хүүхэд хөгжих таатай орчинд хүүхэд бүрийн хөгжлийг дэмжин, тэдний өөртөө итгэлтэй, бүтээлч чадварыг нээн хөгжүүлж сургуулийн өмнөх насны хүүхдэд боловсрол олгох” зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Монгол Улсын бага, дунд боловсролын тухай хуульд бага, суурь, бүрэн дунд боловсролын зорилгыг:

- ✓ Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай Монгол хүүхэд төлөвшүүлэх;
- ✓ Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх;
- ✓ Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх гэж тодорхойлсон.

Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтална.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөх, боловсруулах, турших, сайжруулах хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг багтаасан тасралтгүй, цогц үйл ажиллагаа байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Цэцэрлэг нь сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, мэдлэг чадвар авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх асран хамгаалагч, дэмжигчтэй хамтран ажиллах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон.Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалт
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн цалингийн доод хэмжээг тогтоосон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,607.6 мянган төгрөгөөр буюу 15,0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	85,633.7	31,677.6	(53,956.1)
Авлага	35.8	0	(35.8)
Бараа материал	32,211.7	39,727.5	7,515.8
Үндсэн хөрөнгө	267,646.0	256,514.4	(11,131.6)
Нийт хөрөнгө	385,527.3	327,919.6	(57,607.6)
Өр төлбөр	36.3	0.8	(35.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	385,490.9	327,918.8	(57,572.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	385,527.3	327,919.66	(57,607.6)

Дээрх хүснэгтээс харахад бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, мөнгөн хөрөнгө, өглөг, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмч данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 31,677.6 мянган төгрөгөөр харагдаж байгаа нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Авлагын дансны 35.8 мянган төгрөгийг залруулга хийсэн нь нөлөөлсөн.

Бараа материал данс өмнөх оноос 7,515.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 54,012.7 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 46,496.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 11,131.6 мянган төгрөгөөр буурсан нь нэмэгдсэн хөрөнгө байхгүй элэгдлийн дүнгээр байгаа нь нөлөөлсөн байна.

Өглөг 0.8 төгрөгөөр нэмэгдсэн нь хүмүүст өгөх татварын өглөгөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 271,336.7 мянган төгрөг, нийт зарлагыг 271,336.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 37,799.6 мянган төгрөгөөр бууруулж, 233,537.1 мянган төгрөгийн зардлыг баталсан байна. Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 23,627.1 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 233,537.1 мянган төгрөгийн санхүүжилт орсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 263,866.0 мянган төгрөг буюу 89,3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 31,677.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	81605-эрүүл мэндийг дэмжих	898.9	898.9	-	100
2	81807-цэцэрлэгийн хүүхдийн хоол	40,181.4	38,844.9	1,336.5	96,7
3	81816-хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,323.2	3,323.0	0.2	99,9
4	81823-боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	898.9	898.9	-	100
5	81832-нүүдлийн бүлэгт хамруулах	19,197.1	11,019.5	8,177.6	57,4
6	81833-явуулын багшийн үйлчилгээ	1,835.9	725.1	1,110.8	39,5
7	81834-боловсролын стандарт% сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	97,802.5	82,818	14,984.5	84,7

8	81835-сургалтын хэвийн үйл ажиллагаа	46,158.6	40,092.5	6,066.1	86,8
	дүн	210,296.5	178,620.8	31,675.7	89,8
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
1	80111-төрийн өмчит барилгын тогтмол зардал	22,279.0	19,238.7	3,040.2	86,5
	дүн	22,279.0	19,238.7	3,040.2	86,5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа хийгдээгүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, Шинжээч Ц.Цацрал Х.Ариунжаргал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, үе шатны хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 646,559.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,698.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,273.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, албан томилолтоор ажилласан зардал хэмнэж ажилласан хэдий ч байгалийн гамшиг, цас, зудын нөхцөл байдалтай уялдуулан онцгой дэглэмээр ажиллаж байгаа шалтгаан нөхцөлийн улмаас зардлын хэмнэлтийг хийх боломжгүй нөхцөл байгааг анхаарч үзсэн болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 135 мэдээллээс 134 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 1 мэдээлэл байршуулсан байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.", гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.
2. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 67,561.5 мянган төгрөгийн зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 51,546.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Улсын бүртгэлийн гэрчилгээнд дээр хөрөнгийн хэмжээ 31,352.0 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 125,616.9 мянган төгрөг Засгийн газрын оролцоо 94,264.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4-д үнэн зөв байх; гэсэнтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийн алдааг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн татварын тухай, Төсвийн тухай хууль, Улсын бүртгэлийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт, өглөгийн данстай холбоотой бүртгэлтэй холбоотой нийт 7 зөвлөмж хүргүүлснээс 3 зөвлөмж 100 хувь хэрэгжүүлэн ажилласан, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,176.3 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс 4 зөвлөмж өгснөөс 100 хувь зөвлөмж хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага					
Зөвлөмж	4	1,176.3	1	1,176.3	100
Нийт дүн	4	1,176.3	1	1,176.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд нийт хувьсах зардлын 2 хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна гэснийг үзэх,
2. Боловсролын шинэчлэлтийн хуулиар олгогдсон бусад эрх хэмжээний асуудлыг үзэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,597.1 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 1,597.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Татварын цахим тайлангийн системээр 2022, 2023 оны газрын төлбөр 5.7 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өглөг үүсгэхгүй ажиллах.

2. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын цахим тайлангийн системээр 2023 оны 12 дугаар сарын тайлан 69.6 мянган төгрөгийн авлагатай байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага үүсгэхгүй ажиллах.

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын 2 нэр төрлийн 1,521.7 мянган төгрөгийн хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн. Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй, тооллого тооцооны үр дүнг хэлэлцээгүй, чанар байдлыг тодорхойлоогүй, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийн жагсаалт, мэдээллийг тодруулга тайлан бэлтгэж тайлагнаагүй байгаа нь СТОУС-13 стандартын 6.12-д "Бодит үнэ цэнэ гэж зах зээлд оролцогчдын хоорондох цэгцтэй ажил гүйлгээгээр хэмжилтийн өдөр хөрөнгийг борлуулснаар хүлээн авах эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх үнийн дүн юм", 6.13-д "Бодит үнэ цэнд зах зээлд оролцогчид буюу тухайн аж ахуйн нэгж нэвтрэх боломжтой зах зээлд оролцогчдын хэтийн төлөв тусгагддаг. Эдийн засгийн ашиг тусын төлөө хамгийн сайн үйл ажиллагаа эрхэлдэг бол хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо тэдний ашиглаж болох ижил төстэй таамаглалыг ашиглан, тэдгээр хөрөнгө өр төлбөрийг хэмждэг" гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр, үнэн зөв бүртгэж, тайлагнадаг байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
2022, 2023 оны газрын төлбөр 5.7 мянган төгрөгийн татвар төлөөгүй өглөгтэй байна.	1	5.7					1	5.7				
Нийгмийн даатгалын цахим тайлангийн системээр 2023 оны 12 дугаар сарын тайлан 69.6 мянган төгрөгийн авлагатай байна	1	69.6					1	69.6				
Байгууллагын 2 нэр төрлийн 1,521.7 мянган төгрөгийн хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн	1	1,521.7					1	1,521.7				
Дүн	3	1,597.1					3	1,597.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцорсон 1 мэдээлэл байршуулсан байна.	1				1			
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 67,561.5 мянган төгрөгийн зарлагыг өссөн дүнгээр оруулаагүй байгаа	1	67,561.5			1	67,561.5		
Дүн	2	67,561.5			2	67,561.5		

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил

Цахим баримт 51,546.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн	1	51,546.3					1	51,546.3
Засгийн газрын оролцоо 94,264.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна	1	94,264.9					1	94,264.9
Дүн	2	145,811.2					2	145,811.2
Нийт дүн	4	213,372.7			2	67,561.5	2	145,811.2



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 34-14510516-ТӨА-2024/

Зуунмод

1251/СА-СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 67,561,500 /жаран долоон сая таван зуун жаран нэгэн мянга таван зуун/ төгрөг өссөн дүнгээр дутуу мэдээлсэн, 1 хугацаа хоцорсон мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх";, 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ";, 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

2. Цаашид алдаа², зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өндөрширээт сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Д.Буянжаргал, нягтлан бодогч Б.Өлзиймаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/



²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582